



## НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 03 сарын 15 өдөр

Дугаар А/20

Улаанбаатар хот

“Зочид буудал, дэн буудал, амралтын газрын”  
үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох,  
хүчингүй болгох тухай

Монгол Улсын Аялал жуулчлалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам”-ын 5.1, Газрын дүрмийн 2.5.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам” болон “Зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS4588:2008” стандартын шаардлагыг хангасан, тушаалын нэгдүгээр хавсралтад дурдсан аж ахуйн нэгжид Зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

2. “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам” болон “Дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS5738:2007” стандартын шаардлагыг хангасан, тушаалын хоёрдугаар хавсралтад дурдсан аж ахуйн нэгжид Дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

3. “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам” болон “Амралтын газарт тавигдах ерөнхий шаардлага MNS6043:2009” стандартын шаардлагыг хангасан, тушаалын гуравдугаар хавсралтад дурдсан аж ахуйн нэгжид Жуулчны баазын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан Цэлмүүн трейд ХХК-ийн “Дрийм” зочид буудлын 17/043, Дельта фүүдс ХХК-ийн “Эвэргрийн” зочид буудлын 15/044, Ундарга ХХК-ийн “Венус” зочид буудлын 17/002, Нью лүсид ХХК-ийн “Тулга” дэн буудлын 16/163 тоот гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

5. Зөвшөөрөл авсан байгууллага болон иргэдтэй гэрээ байгуулж үр дүнг тооцон ажиллахыг Захиргааны хэлтэс /Д.Ганболд/-т үүрэг болгосугай.

6. Энэхүү тушаалыг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Нийслэлийн Цагдаагийн газар болон дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг Үйлчилгээний байгууллага, стандарт хариуцсан мэргэжилтэн /Б.Амар/-д үүрэг болгосугай.

7. Гэрчилгээний үнэ болох 5000 /таван мянга/ төгрөгийг байгууллага болон иргэн тус бүрээс хураан, Төрийн сан банкны 100200051053 тоот дансанд төвлөрүүлэн, зөвшөөрлийн гэрчилгээний бичилт, олголтод байнгын хяналт тавьж ажиллахыг Ахлах нягтлан бодогч /Б.Батбаатар/-д даалгасугай.

ДАРГА *D. Batsukh* Д.БАТСҮХ

1117139265  
УОА0453 5284325

1150500050

Нийслэлийн Аялал жуулчлалын  
газрын даргын 2018 оны 3 сарын 15  
өдрийн 140 дугаар тушаалын нэгдүгээр  
хавсралт

1117139265  
УОА0453 5284325

ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ  
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН  
ЖАГСААЛТ

2018.03.15

Улаанбаатар хот

| Д/д | Иргэн, аж ахуйн нэгжийн нэр | Эзэмшигчийн регистрийн дугаар | Оноосон нэр | Байршил   |
|-----|-----------------------------|-------------------------------|-------------|---|
| 1   | Цэлмүүн трейд ХХК           | 2693135                       | Дрийм       | ЧД-ийн 4-р хороо Бага тойруу Анкарагийн гудамж 19-2 |
| 2   | Дельта фүүдс ХХК            | 2562456                       | Эвэргрийн   | БГД-ийн 3-р хороо Тээвэрчдын гудамж 6               |
| 3   | Ундарга ХХК                 | 2099853                       | Венус       | БЗД-ийн 7-р хороо 4а                                |
| 4   | Оч энд ХХК                  | 2862034                       | Гүн нуур    | БГД-ийн 7-р хороо Энэр төв                          |

-ооОоо-

Нийслэлийн Аялал жуулчлалын  
газрын даргын 2018 оны 03 сарын 15  
өдрийн А/АД дугаар тушаалын  
хоёрдугаар хавсралт

1117139265  
УОА0453 5284325

ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ  
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН  
ЖАГСААЛТ

2018.03.15

Улаанбаатар хот

| Д/д | Иргэн, аж ахуйн нэгжийн нэр | Эзэмшигчийн регистрийн дугаар | Оноосон нэр | Байршил                                      |
|-----|-----------------------------|-------------------------------|-------------|--|
| 1   | Нью лүсид ХХК               | 5443326                       | Тулга       | БГД-ийн 3-р хороо ЕХЕ центр, 3,4 давхар      |
| 2   | Чанцоло ХХК                 | 2858657                       | Дөлгөөхөн   | БГД-ийн 10-р хороо зүүн нарангийн 01-08 тоот |
| 3   | Ар дайрга ХХК               | 5036046                       | Оч          | СХД-ийн 5-р хороо Баянголын 65-12            |

-ooOoo-

Нийслэлийн Аялал жуулчлалын  
газрын даргын 2018 оны 03 сарын 15  
едрийн 1120 дугаар тушаалын  
гуравдугаар хавсралт

1117139265  
УОА0453 5284325

ЖУУЛЧНЫ БААЗЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ  
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН  
ЖАГСААЛТ

2018.03.15

Улаанбаатар хот

| Д/д | Иргэн, аж ахуйн нэгжийн нэр | Эзэмшигчийн регистрийн дугаар | Оноосон нэр   | Байршил  |
|-----|-----------------------------|-------------------------------|---------------|--|
| 1   | Бага хандгайт<br>ОНӨААТҮГ   | 8179492                       | Бага хандгайт | СБД-ийн 19-р хороо<br>Багахандгайтын 3-р хэсэг |

-ооОоо-